



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 02. 15 № 3/186
танай _____-ны № _____-т

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН
ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Д.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аудит хийв.

Улсын драмын эрдмийн театрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА





YAG

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

YAG-ын Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 261585
Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512
Цахим хаяг: ganbilegd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Монгол Улсын Үндэсний
аудитын газар
Засгийн газрын IV байр, Бага тойруу-6,
Улаанбаатар-46, Монгол улс
Веб сайт: www.audit.mn



“МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

Гүйцэтгэх захирал: С.Мөнхбаяр
Утас: 88106070
Цахим хаяг: info@magicgroup.mn
Ахлах аудитор: Ч.Насанбат
Утас: 99089293
Цахим хаяг: Otgonbaatar.g@magicgroup.mn

Аудитор: Г.Отгонбаатар
Утас: 91091696
Цахим хаяг: audit@magicgroup.mn
Хаяг:

УБ хот Чингэлтэй дүүрэг 1-р хороо
Гандирс Төвийн 5-р давхар 504 тоот

**УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТР
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	4
5. Материаллаг байдлын түвшин	5
6. Дотоод хяналт	5
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	5
8. Шилэн дансны мэдээлэл	6
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	6
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	6
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	7
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:	8
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	8

НЭГ.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан журам, 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.7 дахь заалтын дагуу Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд (САГ-2017/312/СТА –ТШЗ) аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд УСНББОУ-ын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус байгууллага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 16 –ны өдрөөс 2 дугаар сарын 6–ны хооронд хийхээр төлөвлөн “Мэжик консалтинг аудит” ХХК-ийн багийн аудитор Ч.Насанбат, аудитор Г.Отгонбаатар нар хийж гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-А-9/

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны санхүүгийн тайлангаа 2016 оны 1 дүгээр сарын 16 -ны өдөр “Межик консалтинг аудит “ХХК –д ирүүлсэн байна.

“Мэжик консалтинг аудит” ХХК аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 10 -наас 2016 оны 2 дугаар сарын 10- ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Улсын драмын эрдмийн театрын удирдлагад гардуулна.

Хоёр.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Улсын драмын эрдмийн театрын захирал нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” ‘Соёлын тухай’ хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхлэж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна. Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой Соёлын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар Засгийн газрын тогтоол, БСШУ-ны сайдын тушаал, Улсын драмын эрдмийн театрын захирлын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Аудитын явцад төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гурав.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Үндэсний болон дэлхийн сонгодог жүжгүүдээр урын сангаа баяжуулах үзэгчдэд чиглэсэн менежментийн оновчтой бодлоготойгоор урлаг уран сайхныг сурталчлах, үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх мэргэжлийн өндөр түвшинд уран бүтээл туурвиж , ард түмний оюуны хөтөч байна гэж үйл ажиллагааны үндсэн зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.1 “ Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсийн шууд захирагчтай байна” гэсэн заалтын дагуу Драмын эрдмийн театрын захирал нь нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн бүхий л хууль, журам зааврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.Төсвөө БСШУСЯмны төрийн сангаар дамжуулан гүйцэтгэж байна.

Улсын драмын эрдмийн театрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаалаар баталсан “ Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”, Шилэн дансны тухай хууль, бусад холбогдох заавар журмуудыг шалгуур болгож, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын гарын авлагын арга зүйг ашиглав.

Аудитаар Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Улсын драмын эрдмийн театрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2008 оны 388 дугаар тушаалаар баталсан “ Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”, бусад холбогдох заавар журамд нийцэж байна. Тус газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Винница програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргаж нэгтгэл хийсэн байна.

Улсын драмын эрдмийн театрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар

танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах асуудлыг судлан үнэлж нарийн мэргэжлийн ажилтан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ. /ТАБ-СТА-В-2/

Тав. Материаллаг байдлын түвшин:

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, нийт төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл болох 1,252,891.2 мян.төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 1 %-иар тооцож материаллаг байдлын хэмжээг 12,528.9 мян. төгрөг гэж урьдчилан тогтоов. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж үзэхэд өөрчлөлт орсонгүй.

Зургаа. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Улсын драмын эрдмийн театрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Улсын драмын эрдмийн театрын захирлын 2006.. оны 41 дүгээр тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах үүрэгтэй ажиллуулан хөрөнгөтэй холбоотой асуудлыг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байна. Мөнгөн хөрөнгийн болон эд хөрөнгийн тооллогыг хууль журманд заасан хугацаанд хийж гүйцэтгэн дүнг удирдлагын зөвлөлд танилцуулж хэвшсэн байна.

Долоо.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Улсын драмын эрдмийн театр 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваариалан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

“Улсын драмын эрдмийн театр”- ын 2016 оны төсвийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 1,351,692.5 мян.төгрөг байхаас гүйцэтгэлээр 1,252,891.2 мян.төгрөг зарцуулж төсвийг 98,801.2 мян.төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна

Өөрийн орлогын гүйцэтгэлийн талаар: Нийт өөрийн орлогын гүйцэтгэл 75.4 хувь буюу 250,285.8 мян/ төгрөг бөгөөд орлогын төлөвлөгөө 24.6 хувь буюу 81,712.7 мян/ төгрөгөөр тасарсан байна.

Өөрийн орлогын судалгаа:

мян/төгрөгөөр

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагаа	56,464.2	22,909.8	(33,554.4)	59.4
Уран бүтээлийн	247,534.3	219,376.0	(28,158.3)	11.4

Туслах үйл ажиллагаа	28,000.0	8,000.0	(20,000.0)	71.4
Нийт орлого	331,998.5	250,285.8	(81,712.7)	24.6

Найм. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай “Шилэн данс”-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.-д “Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно” гэсэн заалтын дагуу тус байгууллагын шилэн дансны мэдээллийг шалгахад www.shilendans.gov.mn вебсайтад 2016 оны төсвийн санхүүжилт болон бусад орлого зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг тухай бүр мөн мэдээллийн самбар дээр төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирлын тайлан балансуудыг байршуулсан байна.

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, байгууллагын нээлттэй, ил тод байх шалгуурыг хэрэгжүүлэх зорилгоор дотоод аудитын дүн мэдээг байгууллагын веб сайтын “Ил тод байдал” цэсэнд байршуулж нээлттэй хүргэсэн төдийгүй Үндэсний аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж байгууллагын хэмжээнд “Шилэн дансны тухай хууль” нь хангалттай хэрэгжиж эхэлсэн байна гэж дүгнэжээ.

Ёс. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Арав.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, элэгдэл, шатах тослох материал, түлш шатахууны зардал, цалин, ндш, хувь хүний орлогын албан татварын ногдуулалт, төлөлт, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт хөрөнгийн 97 хувь, зардлын 50 хувийг тус тус хамарсан болно.

- Улсын драмын эрдмийн театрын санхүүгийн тайланд хийсэн балансын шинжилгээгээр тоног төхөөрөмж 45.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар шийдэгдэн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн 55.0 сая төгрөгнөөс зохих журмын

дагуу худалдан авсан тоног төхөөрөмжийн мөн тавилга эд хогшил 8,7 сая, төгрөгөөр өссөн нь Улсын драмын эрдмийн театрын 85 жилийн ой болсонтой холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас хандиваар өгсөн тавилга эд хогшлийг зохих журмын дагуу бүртгэн авсантай холбоотой байна

- Улсын драмын эрдмийн театрын захирлын 2015 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 01 дүгээр тушаалаар зохион байгуулалтын бүтэц, орон тоо 129 албан хаагчидтай байхаар батлагдсанаас тайлант онд гүйцэтгэлээр 126 албан хаагчидтайгаар ажиллаж, цалингийн сан 12.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

- Тайлант онд ХХОАТ, цахилгаан, дулаан, цэвэр ус болон нийгмийн даатгалын шимтгэлийн ямар нэгэн өр үүсгээгүй холбогдох газруудтай тооцоо нийлэн үлдэгдлийн баталгааг маягтын дагуу хийж баталгаажуулан авлаа.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа илрээгүй болно.

Арван хоёр. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг түүвэрлэн шалгахад 2015 оны жилийн эцсээр хувь хүмүүстэй холбоотой авлага болох цалингаас тооцсон 79.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын суутгалыг буруу бичилт хийж нэгтгэн зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтын дагуу өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгөх.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй болно.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 79.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Улсын драмын эрдмийн театрын удирдлагын анхааралд хандуулж 2 зөвлөмж өгсөн.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Тус байгууллагын 2015 оны санхүүгийн тайланд “Монголиан бизнес рейтинг Аудит” ХХК-иас хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 4 хуудас, менежментийн захидал 4 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ЗОЛЗАЯА

АХЛАХ АУДИТОР

Д.ГАНБИЛЭГ

БЭЛТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.МӨНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

Ч.НАСАНБАТ

АУДИТОР

Г.ОТГОНБААТАР



YAG

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

YAG-ын санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 261585
Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512
Цахим хаяг: Ganbilegd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Монгол Улсын Үндэсний
аудитын газар
Засгийн газрын IV байр, Бага тойруу-6,
Улаанбаатар-46, Монгол улс
Веб сайт: www.audit.mn



“МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

Гүйцэтгэх захирал: С.Мөнхбаяр
Утас: 88106070
Цахим хаяг: info@magicgroup.mn

Ахлах аудитор: Ч.Насанбат
Утас: 99089293
Цахим хаяг: ch_nasanbat@magicgroup.mn

Хаяг:

УБ хот Чингэлтэй дүүрэг 1-р хороо
Гандирс Төвийн 5-р давхар 504 тоот

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Менежментийн захидал

2017 оны 2 дүгээр сар 7

Менежментийн захидал

Манай Аудитын компани Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дахь заалт, Монгол Улсын ерөнхий аудиторов 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэх журам”-ын 2.7-д заасны дагуу Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийв.

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг танай байгууллагын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү Менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандартад тулгуурлан бидний гүйцэтгэсэн аудитын горим, ажлын үр дүнгээс үүдэн гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад шаардлагатай баримт материалыг цаг хугацаандаа гаргаж өгч, биднийг мэдээллээр хангаж байсныг сайшаан тэмдэглэж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Улсын драмын эрдмийн театрын захирал Д.Цэрэнсамбуу, ахлах нягтлан бодогч Л.Нина болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.МӨНХБАЯР

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал :

Асуудал 1 Авлага,өглөгийн талаар	
Ажиглалт: 1 Авлага,өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг түүвэрлэн шалгахад 2015 оны жилийн эцсээр хувь хүмүүстэй холбоотой цалингийн 79.2 мянган төгрөгийн авлага болох ХХОАТ-ын суутгалыг буруу бичилт хийж нэгтгэн зөрүүтэй тайлагнасан байсныг залруулах бичилт хийж тайлагнах Эрсдэл : -Дансны бичилт буруу хийгдсэн байх; -Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;	Зөвлөмж: УСНББОУС-ын дагуу ажил гүйлгээг үнэн зөв бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланг толилуулах ба бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах; Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 6 сарын 30-ны дотор өгөх; Үйлчлүүлэгчийн хариу : -Аудитын асуудлын бүртгэлийг удирдлага санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулан хэрэгжүүлж ажиллахаар болсон.
Асуудал.2 Санхүүгийн тайлагналын талаар	
Ажиглалт: 2 Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэж тайлагнаагүй байна.	Зөвлөмж: Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэж тайлагнаж хэвших Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 06

Эрсдэл • Хууль тогтоомж журам хэрэгжихгүй байх • Санхүүгийн тайлан болон тодруулгыг үнэн зөв бүрэн бэлтгээгүй байх нь хэрэглэгчид мөн удирдлагыг бодит мэдээлэлээр хангахад эрсдэл үүсэх магадлалтай .	сарын 30-ны дотор өгөх; Үйлчлүүлэгчийн хариу: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар боллоо.
---	---

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН
ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Д.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аудит хийв.

Улсын драмын эрдмийн театрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын драмын эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын драмын эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аудитын нэр: Улсын драмын эрдмийн театрын 2016 оны санхүүгийн тайлан

Аудитын код: САГ-2017/312/ СТА -ТШЗ

Аудитын багийн нэр: “Мэжик консалтинг-Аудит” ХХК

Тайлант жил : 2016 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэн огноо		Тайлбар
		Анхан шатны хяналт	Хоёрдах шатны хяналт	
1	Аудитын тайлан			
2	Санхүүгийн аудитын газрын даргаар гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн Аудитын гэрчилгээ			
3	Менежментийн захидал			
	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан			
4	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан			
5	Акт, албан шаардлагын төсөл	Байхгүй	Байхгүй	
6	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			

Бэлтгэсэн: Аудитор

Ч.Насанбат

Анхан шатны хяналт хийсэн: аудитын менежер

Г.Мөнхбаяр

Хоёрдах шатны хяналт хийсэн: Захирал

С.Мөнхбаяр

Аудитын менежерийн санал:

Захирлын санал:

Байгууллагын нэр: Улсын драмын эрдмийн театр

Санхүүгийн байдлын тайлан

12/31/2016

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	394,108,132.32	385,346,456.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	160.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31110	Төгрөг	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	160.00
31210	Төгрөг	0.00	160.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31212	Монгол банкин дахь харилцах	0.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	160.00
33	АВЛАГА	93,350.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.00
33500	Бусад авлага	93,350.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	93,350.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	394,014,782.32	385,346,296.32
35100	Түүхий эд материал	3,414,882.00	4,320,340.00
35110	Тусгай зориулалттай материал	3,414,882.00	4,320,340.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	39,935,000.00	27,886,500.00
35400	Хангамжийн материал	350,664,900.32	353,139,456.32
35410	Бичиг хэргийн материал	196,000.00	0.00
35420	Аж ахуйн материал	0.00	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	60,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35450	Барилгын засварын материал	0.00	0.00
35460	Хүнсний материал	0.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	350,408,900.32	353,079,456.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,258,453,758.63	1,180,321,610.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,258,453,758.63	1,180,321,610.86
39200	Биет хөрөнгө	1,258,453,758.73	1,180,321,610.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,844,568,493.00	2,844,568,493.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,837,169,064.16	-1,884,578,539.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,586,865.00	137,586,865.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-79,836,335.92	-95,964,155.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	782,680,343.46	827,680,343.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-678,434,188.74	-729,428,890.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	217,168,679.70	225,948,023.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-142,535,428.61	-156,856,135.93
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	11,143,597.00	11,143,597.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,455,080.00	52,455,080.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-49,174,282.00	-52,233,070.10
39300	Биет бус хөрөнгө	-0.10	0.00
39301	Програм хангамж	2,800,000.00	2,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,800,000.10	-2,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,652,561,890.95	1,565,668,067.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	812,770.90	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	177,485.61	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	635,285.29	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,651,749,120.05	1,565,668,067.18
51	Засгийн газрын хувь оролцоо	1,651,749,120.05	1,565,668,067.18
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,150,922,963.73	3,150,922,963.73
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,499,173,843.68	-1,585,254,896.55
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,438,073,692.32	-1,499,173,843.68
51220	Тайлант үеийн үр дүн	-61,100,151.36	-86,081,052.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,652,561,890.95	1,565,668,067.18

Байгууллагын нэр: Улсын драмын эрдмийн театр
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

12/31/2016

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	394,108,132.32	385,346,456.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	160.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31110	Төгрөг	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	160.00
31210	Төгрөг	0.00	160.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31212	Монгол банкин дахь харилцах	0.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	160.00
33	АВЛАГА	93,350.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.00

33500	Бусад авлага	93,350.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	93,350.00	0.00
